

Сарын урьдчилсан төлөв

2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН МЭДЭЭ

ТАНЫ АНХААРАЛД

Дэлхийн цаг уурын байгууллагаас тогтоосноор олон жилийн дундаж (ОЖД) утга гэдэг нь 1991–2020 оны хоорондох тухайн цаг уурын хэмжигдэхүүний дундаж утгыг авч үздэг. Сарын цаг агаарын урьдчилсан мэдээнд сарын дундаж агаарын температур, нийлбэр хур тунадасны хэмжээг дараах дөрвөн бүс нутгаар тус бүрээр урьдчилан мэдээлнэ.


- о **Баруун** (Баян-Өлгий, Увс, Ховд, Завхан, Говь-Алтай, Баянхонгор)
- о **Төв** (Өвөрхангай, Архангай, Хөвсгөл, Булган, Орхон, Сэлэнгэ, Дархан-Уул, Төв)
- о **Зүүн** (Хэнтий, Дорнод, Сүхбаатар)
- о **Говь** (Өмнөговь, Дундговь, Дорноговь, Говь-Сүмбэр)

Цаг агаарын үзэгдэл нутгийн 30 хувиас хэтрэхгүйгээр зурвас газраар ажиглагдах тохиолдолд "зарим газраар", 30-70 хувьд "ихэнх нутгаар", 70 хувиас дээш нутгийг хамрах тохиолдолд "нийт нутгаар" гэсэн нэр томъёо хэрэглэдэг. Дулааны улиралд агаарт болон хөрсний гадарга дээр температур 0°-аас бага болж хүйтрэхийг "цочир хүйтрэл" гэнэ.


Сар, улирлын урьдчилсан мэдээний талаар лавлах бол Ус, Цаг Уур, Орчны Судалгаа Мэдээллийн Хүрээлэнгийн 11-326606 утсаар холбогдох болон тус хүрээлэнгийн "Хиймэл оюун ухаан, тоон загварчлал, судалгааны хэлтэс"–ээс тодруулах боломжтой.

Уур амьсгалын тойм

Сарын дундаж агаарын температур ОЖД–аар Баян–Өлгий, Завхан, Хөвсгөлийн ихэнх нутаг, Баянхонгорын хойд, Архангайн баруун, Төв аймгийн зүүн хойд хэсгээр 6–12°C, Ховд, Говь–Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Дундговийн өмнөд хэсэг, Дорноговь, Өмнөговийн нутгаар 20–24°C, бусад нутгаар 13–19°C дулаан байдаг (**Зураг 1**). Агаарын дундаж температур болон хур тунадас олон жилийн явцыг зураг 3–д харуулав. Зургаас харахад 1980–1999, 2012–2016 оны хооронд дараалан ОЖД–аас хүйтэн байсан бол 2000–2014, 2017-2019, 2022-2024 онуудад дараалан ОЖД–аас дулаан байсан байна. Харин 1983 оны 6–р сард ОЖД–аас 3°C–аар хүйтэн байсан нь 1979 оноос хойш тохиолдсон хамгийн хүйтэн, 2017 оны 6–р сард ОЖД–аас 2°C–аар дулаан буюу түүхэн дэх хамгийн дулаан сар болж өнгөрсөн байна (**Зураг 2**).



Зураг 1. 6-р сарын агаарын температурын ОЖД, [°C]




Зураг 2. 6-р сарын агаарын температурын олон жилийн явц


[Улаан – ОЖД-аас дулаан, хөх – ОЖД-аас хүйтэн]

Сарын нийлбэр хур тунадас ОЖД-аар Хөвсгөл, Архангай, Булган, Сэлэнгийн ихэнх нутаг, Төв, Хэнтий, Дорнодын хойд хэсгээр 60–70 мм, Ховд, Говь-Алтай, Өмнөговь, Дорноговийн нутаг, Баянхонгор, Дундговийн өмнөд хэсгээр 10–20 мм, бусад нутгаар 20–60 мм хур тунадас ордог (**Зураг 3**). Хур тунадасны хувьд 1979–1982, 1995–2007, 2017–2020 онуудад дарааллан ОЖД-аас бага байсан бол 1983–1986, 1988–1991, 2011–2016 онуудад ОЖД-аас харьцангуй ахиу хур тунадас орсон байна. 2017 онд нийт нутгийн дунджаар ОЖД-аас 15 мм-ээр бага тунадас орсон нь

түүхэн дэх хамгийн хуурай 6-р сар болсон бол 1994 онд ОЖД-аас 26 мм-ээр ахиу тунадас орсон нь 1979 оноос хойшхи хамгийн ахиу тунадастай 6-р сар болсон байна (**Зураг 4**).



Зураг 3. 6-р сарын нийлбэр хур тунадасны ОЖД, [мм]



Зураг 4. 6-р сарын нийлбэр хур тунадасны олон жилийн явц
 [Ногоон – ОЖД-аас ахиу, шар – ОЖД-аас бага]

ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ


Баруун аймгуудын нутгаар. Энэ сард агаарын дундаж температур нийт нутгаар ОЖД–аас дулаан (**Зураг 5**), хур тунадас Баян-Өлгий, Ховд, Говь–Алтайн нутаг, Увсын баруун, Баянхонгорын өмнөд хэсгээр ОЖД–бага, бусад нутгаар дунджийн орчим орох төлөвтэй байна (**Зураг 6**). Агаарын температур, хур тунадасны явцыг **Зураг 7**–д харуулав. Сарын эхээр ихэнх нутгаар дулаан байх хэдий ч нэгдүгээр арав хоногийн дунд үеэр сэрүүсэж, ОЖД–аас 3–5°C–аар хүйтэн байна. Мөн хоёрдугаар арав хоногийн дунд, гуравдугаар арав хоногийн дунд болон сүүлчээр ихэнх нутгаар ОЖД–аас 1–3°C–аар хүйтэн байх төлөвтэй байна. Харин нэг ба хоёрдугаар арав хоногийн сүүлч, гуравдугаар арав хоногийн дунд үеэр ихэнх нутгаар ОЖД–аас 1–3°C–аар дулаан байна. Хур тунадас хоёрдугаар арав хоногийн дунд болон сүүлч, гуравдугаар арав хоногийн ихэнх хугацаанд (ялангуяа сарын сүүлээр) нутгийн зарим хэсгээр бороо, дуу цахилгаантай аадар бороо орж, салхи ширүүснэ.

Төвийн аймгуудын нутгаар. Энэ сард агаарын дундаж температур Хөвсгөл, Архангай, Өвөрхангайн нутгаар ОЖД–аас дулаан (**Зураг 5**), бусад нутгаар дунджийн орчим байх бол хур тунадас нийт нутгаар дунджийн орчим орох төлөвтэй байна (**Зураг 6**). Агаарын температур, хур тунадасны явцыг **Зураг 8**–д харуулав. Нэгдүгээр арав хоногийн дунд үеэр ихэнх нутгаар ОЖД–аас 3–5°C–аар хүйтэн байна. Мөн хоёрдугаар арав хоногийн дунд, гуравдугаар арав хоногийн сүүлчээр ихэнх нутгаар ОЖД–аас 1–2°C–аар сэрүүн байх төлөвтэй байна. Харин нэгдүгээр арав хоногийн сүүлч, хоёрдугаар арав хоногийн эхэн болон сүүлч, гуравдугаар арав хоногийн эхээр ихэнх нутгаар ОЖД–аас 1–3°C–аар дулаан байна. Хур тунадас нэгдүгээр арав хоногийн эхэн, хоёрдугаар арав хоногийн эхэн болон дунд, гуравдугаар арав хоногийн дунд үеүдэд бага зэрэг, гуравдугаар арав хоногийн сүүлчээр (ялангуяа сарын сүүлээр) ихэнх нутгаар бороо, дуу цахилгаантай аадар бороо орж, салхи ширүүсэх төлөвтэй байна.

Зүүн аймгуудын нутгаар. Энэ сард агаарын дундаж температур Сүхбаатарын өмнөд хэсгээр ОЖД–аас дулаан, бусад нутгаар дунджийн орчим, хур тунадас Дорнод, Сүхбаатарын нутгаар ОЖД–аас ахиу, бусад нутгаар дунджийн орчим орох байх төлөвтэй байна (**Зураг 5, 6**). Агаарын температур, хур тунадасны явцыг **Зураг 9**–д харуулав. Нэгдүгээр арав хоногийн ихэнх хугацаанд сэрүүн, ялангуяа дунд үеэр ихэнх нутгаар ОЖД–аас 3–5°C–аар хүйтэн байна. Харин хоёр болон гуравдугаар арав хоногийн ихэнх хугацаанд ОЖД–аас 1–3°C–аар дулаан байх төлөвтэй байна. Хур тунадас нэгдүгээр арав хоногийн дунд, хоёрдугаар арав хоногийн эхэн үеүдэд зарим газраар, гуравдугаар арав хоногийн дунд болон сүүлчээр ихэнх нутгаар бороо, дуу цахилгаантай аадар бороо орж, салхи ширүүсэж болзошгүй байна.


Говийн аймгуудын нутгаар. Энэ сард агаарын дундаж температур нийт нутгаар ОЖД–аас дулаан, хур тунадас Дорноговийн нутгаар ОЖД–аас ахиу, бусад нутгаар дунджийн орчим орох төлөвтэй байна (**Зураг 5, 6**). Агаарын температур, хур тунадасны явцыг **Зураг 10**–т харуулав. Сарын эхээр ихэнх нутгаар дулаан байх хэдий ч нэгдүгээр арав хоногийн дунд үеэр сэрүүсэж, ОЖД–аас 2–5°C–аар хүйтэн байна. Мөн хоёрдугаар арав хоногийн дунд, гуравдугаар арав хоногийн дунд болон сүүлч үеүдэд ихэнх нутгаар ОЖД–аас 1–2°C–аар сэрүүн байна. Харин хоёрдугаар арав хоногийн ихэнх хугацаанд ОЖД–аас 1–3°C–аар дулаан өдрүүд үргэлжлэх төлөвтэй байна. Хур тунадас нэгдүгээр арав хоногийн сүүлч, хоёрдугаар арав

хоногийн сүүлч, гуравдугаар арав хоногийн эхэн болон сүүлч үеүүдэд зарим газраар дуу цахилгаантай аадар бороо орж, салхи ширүүсэх магадлалтай байна.




Зураг 5. 2026 оны 6-р сарын агаарын дундаж температурын урьдчилсан төлөв, C°

[Д-агаарын температур ОЖД-аас дулаан, Н-агаарын температур ОЖД-ийн орчим]




Зураг 6. 2026 оны 6-р сарын нийлбэр хур тунадасны урьдчилсан төлөв, мм

[Н-хур тунадас ОЖД-ийн орчим, И-хур тунадас ОЖД-аас ахиу, Б-хур тунадас ОЖД-аас бага]




Зураг 7. Баруун аймгуудын нутгийн 2026 оны 6-р сарын агаарын температур, хур тунадасны явц

[Үргэлжилсэн хар зураас – агаарын дундаж температурын ОЖД, тасархай хар зураас – агаарын дундаж температурын ОЖД-аас хазайх хазайц, улаан – агаарын дундаж температур ОЖД-аас дулаан, хөх – агаарын дундаж температур ОЖД-аас хүйтэн, ногоон – хур тунадасны хэмжээ]




Зураг 8. Төвийн аймгуудын нутгийн 2026 оны 6-р сарын агаарын температур, хур тунадасны явц

[Үргэлжилсэн хар зураас – агаарын дундаж температурын ОЖД, тасархай хар зураас – агаарын дундаж температурын ОЖД-аас хазайх хазайц, улаан – агаарын дундаж температур ОЖД-аас дулаан, хөх – агаарын дундаж температур ОЖД-аас хүйтэн, ногоон – хур тунадасны хэмжээ]



Зураг 9. Зүүн аймгуудын нутгийн 2026 оны 6–р сарын агаарын температур, хур тунадасны явц

[Үргэлжилсэн хар зураас – агаарын дундаж температурын ОЖД, тасархай хар зураас – агаарын дундаж температурын ОЖД-аас хазайх хазайц, улаан – агаарын дундаж температур ОЖД-аас дулаан, хөх – агаарын дундаж температур ОЖД-аас хүйтэн, ногоон – хур тунадасны хэмжээ]



Зураг 10. Говийн аймгуудын нутгийн 2026 оны 6–р сарын агаарын температур, хур тунадасны явц

[Үргэлжилсэн хар зураас – агаарын дундаж температурын ОЖД, тасархай хар зураас – агаарын дундаж температурын ОЖД-аас хазайх хазайц, улаан – агаарын дундаж температур ОЖД-аас дулаан, хөх – агаарын дундаж температур ОЖД-аас хүйтэн, ногоон – хур тунадасны хэмжээ]

ЗӨВЛӨМЖ

Энэ сард агаарын дундаж температур баруун болон говийн аймгуудын нутаг, төвийн аймгуудын нутгийн баруун хэсгээр ОЖД–аас дулаан байна. Хур тунадас нутгийн баруун өмнөд хэсгээр дунджаас бага, зүүн өмнөд хэсгээр дунджаас ахиу орж, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байна. Муудалтын үеүдийн хувьд сарын эхээр баруун аймгуудын нутгаар дулаан байх хэдий ч зүүн аймгуудын

нутгаар сэрүүвтэр байх ба цаашлаад нэгдүгээр арав хоногийн дунд үеэр ихэнх нутгаар эрс сэрүүсэж, хүчтэй салхи шуургатай байх магадлал өндөр байна. Иймд мал бэлчээрлэлт, үрсэлгээ хамгаалалт болон хол замд гарахдаа анхаарал болгоомжтой байж, богино хугацааны нарийвчилсан урьдчилсан мэдээг тогтмол авч ашиглахыг зөвлөж байна. Цаашдаа 2 дугаар арав хоногийн ихэнх хугацаанд ихэнх нутгаар ОЖД-аас дулаан өдрүүд зонхилох тул хуурайшилт нэмэгдэж болзошгүй байна. Иймд ногоон бүсэд аялахдаа галын аюулгүй байдлыг сахиж, ой хээрийн түймрээс сонор сэрэмжтэй байхыг анхааруулж байна. Харин гуравдугаар арав хоногийн дунд болон сүүлчээр зарим газраар бороо, дуу цахилгаантай аадар бороо орох магадлал нэмэгдэх тул болзошгүй үер ус, мөндөр, нөөлөг салхины аюулаас сонор сэрэмжтэй байхыг анхааруулж байна.